

“МОНОС ХҮНС” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 19-ны өдөр

№^{25/02}

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5 дахь заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, “Монос хүнс” ХК-ийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.5, 11.6 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 28 тоот тогтоол, 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монос хүнс” ХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас 37% (гучин долоон хувь)-иар буюу 1,635,401,712 (Нэг тэрбум зургаан зуун гучин таван сая дөрвөн зуун нэг мянга долоон зуун арван хоёр) төгрөгийг мөнгөн хэлбэрээр тооцож, нэгж хувьцаанд 4 (дөрвөн) төгрөгийн ногдол ашгийг хуваарилахыг зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас холбогдогдох хууль тогтоомжийн дагуу хувь хүний болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, олон нийт буюу 30%-ийн хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-аар дамжуулан 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөрт багтаан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах, үлдэгдэл 70%-ийн хувьцаа эзэмшигчийн ногдол ашгийг компани дээрээс 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөрт багтаан шилжүүлэхийг Гүйцэтгэх захирал (А.Отгондарь), Санхүү хариуцсан захирал (Ц.Дэлгэрмаа) нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавих, ногдол ашиг тараах мэдээллийг зохих журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Н.Цагаанхүү)-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Х.АНАНД